



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/119

Номгон

Хүүхдийн 9,18,16 сартайд цогц  
илрүүлэг үзлэг хийх сургалтыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалт Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүүхдийн 9,18,36 сартайд цогц илрүүлэг үзлэг хийх сэдэвт сургалтыг 2022 оны 12 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Сургалтын үйл ажиллагааны удирдамжийг нэгдүгээр, хөтөлбөрийг хоёрдугаар, зарцуулах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сургалтад зарцуулагдах 32.219,000 (Гучин хоёр сая хоёр зуун арван есөн мянга) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д даалгасугай.

ДАРГА  Н.ЭНХЖАРГАЛ

642201449

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 20 ны өдрийн 119 дугаар тушаалийн нэгдүгээр хавсралт

## УДИРДАМЖ

“Хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг” хийх сургалт зохион байгуулах тухай

### Үндэслэл

Бага насны хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийг дэмжих хамгаалахад гэр бүл, эцэг эх болон өрхийн эмч, эмнэлгийн мэргэжилтний хамтын ажиллагаа нэн чухал бөгөөд олон улсад хүүхдийн тодорхой хөгжлийн насанд үзлэгт хамруулж аливаа эмгэг болон хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэн хөгжлийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах үйл ажиллагаа хэвшсэн байдаг.

Хүүхдийн бие бялдар, эрүүл мэнд, хөгжлийг цогцоор нь тандаж хянаж, аливаа эмгэг болон хөгжлийн хоцрогдлын эрсдэлтэй хүүхдийг бага насанд нь олж илрүүлэх үйл явц нь анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг өрх сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай холбоотой. 2021 оны 12 -р сард Хөдөлмөр нийгмийн хамгаалал, Боловсрол, шинжлэх ухаан, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал” -ыг хэрэгжүүлэхэд өрх сумын эрүүл мэндийн ажилтан бүрийг 9,18,36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн иж бүрэн үзлэг хийх арга барилыг эзэмшүүлэх сургалтанд хамруулах шаардлагатай байна.

Хүүхдийн эмч нар хүүхдийн хөгжлийн хоцрогдлын дөнгөж 30 орчим хувийг илрүүлдэг бол хяналтын хуудас, үзлэг нь 70 орчим хувийг илрүүлж чаддаг гэсэн судалгаа байдаг.

Дээр дурдсан 3 сайдын тушаал болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 тоот тушаалын 5.2.6 -д “хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн дэмжлэгт хамруулах чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэнг сургах” заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдэд эрүүл мэнд, хөгжлийн иж бүрэн үзлэг хийх аргыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн ажилтнуудад зааж сурган үйл ажиллагааг тогтмолжуулах шаардлагатай байна.

**Зорилго:** Баянхонгор аймгийн сум өрхийн нийт 58 эмч нарт хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн эрт илрүүлэг үзлэг хийх аргыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулах

### Үйл ажиллагааны чиглэл

1. Эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх сургалтыг ( 2 хоног) зохион байгуулах
2. Нэг удаагийн үзлэг зохион байгуулж дадлага хийх 1 өдөр

**Хамрах хүрээ :** Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг, 20 СЭМТ, 4 ӨЭМТ

**Оролцох хүний тоо:** 58

**Хугацаа :** 2022 оны 12 дугаар сарын 19-22 өдрүүдэд



Нийт зардал: 32,219,000 төгрөг

Зохион байгуулагч байгууллага : Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар

Санхүүжүүлэгч : НҮБ -ийн хүүхдийн сан

Хүлээгдэж буй үр дүн: Хүүхдийг тодорхой насанд эрүүл мэнд, хөгжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан хөгжлийн хоцрогдол болон бусад өвчин эмгэгийг илрүүлэх талаар орон нутгийн чадавх сайжирч эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулах боломж бүрдэнэ

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ бэхжинэ. ХНХ, БШУ, ЭМ -ийн сайд нарын хамтарсан тушаал хэрэгжилтийг хангана .

ХЯНАСАН

ДАРГА

Н.ЭНХЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН



Г.ЛХАГВА-ОЧИР

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 20 ны өдрийн 119 дугаар тушаалийн хоёрдугаар хавсралт

**“9,18, 36 САРТАЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ЦОГЦ ҮЗЛЭГ” ХИЙХ АРГАЧЛАЛ ТАНИЛЦУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

2022 оны 12 дугаар сарын 19

Дуурсах


Цаг	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
<b>1 дэх өдөр</b>		
09:00-09:20	Бүртгэл	Г.Лхагва-Очир (ЭМГ мэргэжилтэн)
09:20-09:40	Нээлт	Н.Энхжаргал /ЭТХ-ийн дарга
09:40-10:00	Сургалтын зорилго, хүлээгдэж буй үр дүн ярилцлага	Сургагч багш нар
10:00-10:10	Сургалтын өмнөх сорил	Хишигжаргал эмч (Оточномгон өрхийн эмч орон нутгийн сургагч багш)
10:30-11:30	Хүүхдийн эрүүл мэнд хөгжлийг хянах олон улсын чиг хандлага яагаад 9,18,36 сартай хүүхэд вэ?	Сургагч багш нар
10:10-10:20	<b>Цайны завсарлага</b>	
10:20-11:30	Хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоо өсөлт хөгжлийн үнэлгээний ач холбогдол, Үзлэг хэрхэн зохион байгуулах вэ, Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр нь урьдчилан сэргийлэх үзлэг эрт илрүүлгийн хэрэгсэл	А.Ганболд (Сургагч багш нар )
11:30-12:00	Хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг эрт илрүүлэх болон эрт үеийн хөгжлийн дэмжлэг, оролцоог хэрэгжүүлэх аргачлал (ЭМ, ХНХ,БШУ,сайд нарын хамтарсан тушаал)	О.Галбадрах /Үндэсний сургагч багш/
12:00-12:25	Үзлэгийн маягтуудыг танилцуулж үзлэг хийх аргыг тайлбарлах	О.Галбадрах /Үндэсний сургагч багш/
12:25-13:00	Үзлэгийн маягтуудын ерөнхий танилцуулга Хүүхдийн бие бялдрын хэмжилтийг хийх	(Сургагч багш нар )
13:00-14:00	<b>Үдийн завсарлага</b>	
14:00-15:00	Хүүхдийн өсөлтийн явцыг хүснэгтэд тэмдэглэх	А.Ганболд (Сургагч багш нар )



15:00-16:10	Хүүхдийн өсөлтийн тэмдэглэгээг тайлбарлах	Сургагч багш нар
15:00-16:10	Хүүхдийн өсөлт болон хооллолтын зөвлөгөө	Сургагч багш нар
15:00-16:10	18 сартай хүүхдийн үзлэгийн маягт хөтлөх, үзлэг хийх аргачлалын дадлага сургалт	Хишигжаргал эмч (Оточномгон өрхийн эмч орон нутгийн сургагч багш)
<b>16:10-16:20</b>	<b>Цайны завсарлага</b>	
16:20-17:00	9 сартай хүүхдэд эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх үзлэгийн маягт дээр ажиллах хүн бүр	Сургагч багш нар
17:00-17:30	18 сартай хүүхдэд эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх үзлэгийн маягт дээр ажиллах хүн бүр	Сургагч багш нар
17:30-18:00	1 дэх өдрийн дүгнэлт хичээл	Сургагч багш нар
<b>2 дах өдөр</b>		
09:00-09:20	Бүртгэл	Г.Лхагва-Очир ЭМГ-ын мэргэжилтэн
09:20-10:00	36 сартай хүүхдэд эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх үзлэгийн маягт дээр ажиллах хүн бүр	Сургагч багш нар
<b>10:00-10:30</b>	Хүүхдийн хөгжлийн үнэлгээний талаар видео хичээл үзүүлэх (12)	Сургагч багш нар
<b>10:30-11:30</b>	<b>Цайн завсарлага</b>	
11:30-12:00	Хүүхдийн хөгжлийг үнэлэх аргууд (МОРБАС)	Сургагч багш нар
12:00-13:00	Хүүхдийг оролцуулан өсөлтийг хэмжих ба эрүүл мэнд, хөгжлийг үнэлэх дадлага хийх, маягт бөглөх	Сургагч багш нар
<b>13:00-14:00</b>	<b>Үдийн завсарлага</b>	
14:00-15:00	Кейс ажиллах	Сургагч багш нар
15:00-16:10	Орон нутагт эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулах	Сургагч багш нар
<b>16:10-16:30</b>	<b>Цайны завсарлага</b>	
16:30-17:00	Үзлэгийн бүртгэл мэдээлэл хяналт шинжилгээ	Сургагч багш нар
17:30-18:00	Мэдээ тайлан гаргах нэгтгэх талаар танилцуулах Сургалтын ахиц, хаалт, ярилцлага	Сургагч багш нар

**Сургалтын танхим /ЭМГ-ын заал/**

**“9,18,36 САРТАЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ЦОГЦ ҮЗЛЭГ” ХИЙХ  
АРГАЧЛАЛ ТАНИЛЦУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**



2022 оны 12 дугаар сарын 21

Дуурсах

Цаг	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
<b>3 дах өдөр</b>		
09:00-09:20	Бүртгэл	Хишигжаргал эмч (Оточномгон өрхийн эмч орон нутгийн сургагч багш)
09:20-09:40	Сургалтын зорилго, хүлээгдэж буй үр дүн ярилцлага	А.Ганболд (Сургагч багш нар )
09:40-10:00	Сургалтын дараах сорил	Хишигжаргал эмч (Оточномгон өрхийн эмч орон нутгийн сургагч багш)
<b>10:00-10:10</b>	<b>Цайны завсарлага</b>	
10:10-10:30 10:30-11:30	Үзлэгийн маягтуудыг танилцуулж үзлэг хийх аргыг тайлбарлах Үзлэгийн дэмжлэгт хяналт хийх	(Сургагч багш нар )
11:30-12:00 12:00-13:00	Хүүхдийн хөгжлийг үнэлэх хичээл заах дадлага , (хүүхдийн үзлэгийн маягт хөтлөх үзлэг хийх аргачлалын дадлага сургалт)	(Сургагч багш нар )
<b>13:00-14:00</b>	<b>Үдийн завсарлага</b>	
14:00-15:00	Үзлэгийн маягтуудыг танилцуулж үзлэг хийх аргыг тайлбарлах	(Сургагч багш нар )
15:00-16:10	3 дах өдрийн дүгнэлт хичээл	Сургагч багш нар
16:10-16:20	Мэдээ тайлан гаргах нэгтгэх талаар танилцуулах	А.Ганболд (Сургагч багш нар )
16:20-17:00	<b>Цайны завсарлага</b>	
17:00-17:30	Сургалтын ахиц, хаалт, ярилцлага	Н.Энхжаргал (ЭМГ-ийн дарга) Сургагч багш нар

**Сургалтын танхим /ЭМГ-ын заал/**



Эрүүл мэндийн газрын даргын 2022  
оны 12 дугаар сарын 20 ны өдрийн 1.69  
дугаар тушаалийн гуравдугаар хавсралт

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зориулалт	Тооцоолол	Дүн	Тайлбар
1	Оролцогчдын бичиг хэргийн зардал	(58 хүн * 8000төг)*	464000	
2	Оролцогчдын цайны зардал	(58 хүн * 4 өдөр * өдөрт *2 удаа* 6000₮)т	2784000	
3	Оролцогчдын үдийн хоолны зардал	(58 хүн *20000₮) * 4 өдөр	3480000	
4	Үзлэгийн маягт сургалтын материал хэвлэх	(2000 хуудас * 300	600000	
5	Орон нутгийн сургагч багшийн цагийн урамшуулал	20000 х 48 цаг х 2 хүн	1920 000	
6	УБ-ын багшийн томилолт	118000 х 4 өдөр х 2 хүн	590 000	
7	Зөвлөх (УБ) багшийн хичээл заасан урамшуулал	50 000 х 24 цаг	1 200 000	
8	Зохицуулагчийн урамшуулал	37500 х 2 хүн х3 өдөр	225 000	
9	Туслахын урамшуулал	30000 х 2 хүн х3 өдөр	180 000	
10	УБ -ын багшийн унааны зардал	600 км х 2 х 1500	1800 000	Машины түрээс жолоочийн байр хоол, шатахууны үнэ багтана
11	Сургалтын байрны зардал	Байгууллага хариуцна		
12	Сумдаас оролцогчдын томилолт	90000 х 40 хүн х 3 өдөр	10 800 000	
13	Сургалтын материал ( танин мэдэхүйн ном, аяга, сойз, ус, гм	150 000 х24	3 600 000	
14	СЭМТ, ӨЭМТ -өөр үзлэгт дэмжлэгт хяналт хийх	14 хоног х 150 000	2100 000	Тээврийн зардал багтсан
15	Самбарын үзэг 4ш, Самбарын цаас-2 багц Бичгийн цаас-1ш, том скоч-2ш, Өнгийн цаас 3 боодол	476000	476000	
16	Сумдаас оролцогчдын унаа	50000х40	2000 000	Сумаас ирэх зайнаас хамаарна
17			<b>32,219,000</b>	